

**“ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨҮГ-ЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТЭД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН
АЖЛЫН ТАЙЛАН**

2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр

Улаанбаатар хот

1. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, арга зүй

“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, үйл ажиллагааны жилийн эцсийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангахад энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго оршино.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.3-т “Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг энэ журмын 6.2.1, 6.2.2-т заасан аргачлалын дагуу тооцож, зорилт, арга хэмжээний дундаж үнэлгээгээр бодлогын зорилго, зорилтын хэрэгжилтийг дараахь ангилалд шилжүүлэн тооцно” гэснийг үндэслэв.

Хоёр. Танилцуулга

Тус газраас 2024 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар 6 төрлийн үүрэг даалгаврын хүрээнд 198 арга хэмжээний биелэлтийг ирүүлсэн бөгөөд үр дүнтэй буюу 100 хувийн хэрэгжилттэй 116, тодорхой үр дүнд хүрсэн буюу 70-99 хүртэл хувийн хэрэгжилттэй 39, эрчимжүүлэх шаардлагатай буюу 31-69 хүртэл хувийн хэрэгжилттэй 4, үр дүнгүй буюу 0-30 хүртэл хувийн хэрэгжилттэй 16 (үүнээс тасарсан 6), үнэлгээнд хамааралгүй 23 арга хэмжээ байна. Нийт хэрэгжилт нь 82.7 хувьтай байна.

2.1. “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний хэрэгжилт:

№	Бүтээгдэхүүн	Ажил, үйлчилгээний тоо	Хэрэгжилтийн ангилал					Биелэлтийн дүн (Хувь)
			Үр дүнтэй буюу 100 хувь	Тодорхой үр дүнд хүрсэн буюу 70-99 хүртэл хувь	Эрчимжүүлэх шаардлагатай буюу 31-69 хүртэл хувь	Үр дүнгүй буюу 30 хувь	Үнэлгээнд оруулаагүй	
1	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	94	59	24	4	5	2	86.0

2.2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт:

№	Эрх зүйн актын нэр	Нийт арга хэмжээ /заалт/	Хэрэгжилт					Биелэлт /хувиар/
			100%	70%	30%	0%	Хугацаа болоогүй	
1	Засгийн газрын тогтоол	3	3	-	-	-	-	100
2	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	1	1	-	-	-	-	-
ДҮН		4	4	-	-	-	-	100

2.3. Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг, даалгаврын хэрэгжилт:

Нийт заалт	Хэрэгжилт					Хүчингүй болсон	Биелэлт /хувиар/
	100%	70%	30%	0%	Хугацаа болоогүй		
22	11	8	1	1	1	-	80.5

2.4. Төрийн нарийн бичгийн даргын тушаалын биелэлт:

Нийт заалт	Хэрэгжилт						Биелэлт /хувиар/
	100%	70%	30%	0%	тасарсан	Хугацаа болоогүй	
4	1	2	1	-	-	-	67.5

2.5. Ил тод, нээлттэй байдлын үнэлгээ:

№	Шалгуур үзүүлэлтийн бүлэг, нэр	Шалгуур үзүүлэлтийн тоо	Хэрэгжилт				Хамааралгүй	Биелэлт /хувиар/
			100%	70%	30%	0%		
1.	Нэг. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	10	4	-	3	1	2	61.3
2.	Хоёр. Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал	6	4	-	2	-	-	76.7
3.	Гурав. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	15	10	2	-	1	2	87.7
4.	Дөрөв. Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	2	1	-	-	-	1	100
5.	Тав. Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал	13	1	-	-	1	11	50
Дүн		46	20	2	5	3	16	76.3

2.6. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ:

№	Мэдээллийн төрөл	Байршуулбал зохих мэдээлэл	Хугацаандаа байршуулсан	Хугацаа хоцроож байршуулсан	Мэдээ байршуулаагүй	Хугацаа болоогүй	Биелэлт /хувиар/
			100%	70%	0%		
1.	Төсөв, гүйцэтгэл	14	11	-	-	3	100
2.	Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт	6	5	-	-	1	100
3.	Бусад	8	5	3	-	-	88.75
Дүн		28	21	3	-	4	96.25

Дөрөв. Дүгнэлт

1. Тус газраас 2024 оны жилийн эцсийн байдлаар 6 төрлийн үүрэг даалгаврын хүрээнд 198 арга хэмжээний биелэлтийг ирүүлсэн бөгөөд үр дүнтэй буюу 100 хувийн хэрэгжилттэй 116, тодорхой үр дүнд хүрсэн буюу 70-99 хүртэл хувийн хэрэгжилттэй 39, эрчимжүүлэх шаардлагатай буюу 31-69 хүртэл хувийн хэрэгжилтэй 4, үр дүнгүй буюу 0-30 хүртэл хувийн хэрэгжилттэй 16 (үүнээс тасарсан 6), үнэлгээнд хамааралгүй 23 арга хэмжээ байна. Нийт хэрэгжилт нь 82.7 хувьтай байна.

2. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан ч хэрэгжүүлж чадаагүй буюу тасарсан 2 арга хэмжээний хувьд:

- Олон улс, улсын чанартай авто зам, замын байгууламжийн ашиглалтын зөрчлийг илрүүлэх зорилгоор хөдөлгөөнт эргүүл тогтмол ажиллуулахаар төлөвлөсөн ч энэ арга хэмжээ (3.5 дугаартай арга хэмжээ)-ний хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлын биелэлт ирүүлээгүй;

- Санхүүгийн тайлан тэнцэлд улирал бүр дүн шинжилгээ хийж, үргүй зардлыг бууруулах, үр ашигтай ажиллах чиглэлээр удирдлагыг мэдээллээр хангах гэсэн арга хэмжээ (4.17 дугаартай арга хэмжээ)-ний хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлын биелэлт тус тус ирүүлээгүй байна.

Тав. Санал, зөвлөмж

1. Тус газраас 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 176 арга хэмжээнээс тасарсан 2 арга хэмжээ, үр дүнгүй буюу 1-30 хүртэл хувийн хэрэгжилттэй 5 арга хэмжээ, тодорхой үр дүнд хүрсэн ч бүрэн дуусгаж чадаагүй 31-69 хүртэл хувийн хэрэгжилттэй 4 арга хэмжээг 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бүрэн тусган, ажлыг эрчимжүүлэхэд чиглэсэн удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах;

2. Цаашид биелэлтийн тайлан ирүүлэхдээ биелэлтэд тавигдах шаардлагуудыг мөрдөж биелэлтийг алдаагүй, тоо баримттай, үнэн зөв боловсруулж, хянан баталгаажуулах гэсэн зөвлөмжийг тус тус хүргүүлж байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР